ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 10 сарын 29 өдөр Дугаар 138 Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.2 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 9.12 дахь заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Магадлан шалгах ажиллагааны 2026 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн дүгнэлтийн дагуу "Мөөндий ХНГШ" ХХК-д "Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх" тусгай зөвшөөрлийг 2026 оны 10 дугаар сарын 29-ний өдрөөс 5 жилийн хугацаагаар олгосугай.

2.Тусгай зөвшөөрөл шинээр олгосон хуулийн этгээдтэй хуульд заасан хугацаанд гэрээ байгуулах, зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэх арга хэмжээ авч ажиллахыг Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар /З.Эрдэнэчулуун/-т, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус хорооны дарга /Ж.Бат-Эрдэнэ/-д тус тус даалгасугай.

ДАРГА Ж.БАТ-ЭРДЭНЭ

ГИШҮҮД Б.АНХБААТАР

Ц.ГАНЗОРИГ

Б.ДАГВАСҮМБЭРЭЛ

Ч.ЗОЛБАЯР

С.ТАМИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР